

Нийгмийн даатгалын үүсэл хөгжил ба онцлог

Д.Ванданмагсар, нийгмийн даатгалын ахмад ажилтан

1. Хүн амын нийгмийн хамгааллын уламжлал, шинэчлэлийн шүтэлцээ, онцлог

Аль ч улс оронд байдаг нийтлэг нэгэн зүйл бол байгалийн нөлөөлөл, эдийн засаг, нийгмийн байдлаас үүдэлтэй элдэв эрсдэл, ядуурлаас иргэдээ хамгаалах үйл ажиллагааг нийгмийн хамгаалал гэсэн утгаар ойлгодог. Өндөр настан, хөдөлмөрийн чадваргүй иргэд, өнчин ядуусыг асран тэтгэх, байгалийн гамшиг, дайн дажины уршгаас ургасан ядуурал хоосролыг арилгахад төр, засгийн үйл ажиллагаа чухал үүрэгтэй. Монгол гүрний хувьд энэ асуудлыг төрийн ухаалаг бодлогоор зохицуулж байсныг түүхэн сурвалж бичгүүдэд тэмдэглэн үлдсэн баримтыг цухас өгүүлье.

1206 онд Их Монгол улс байгуулагдсан үеэс өнчин ядуусыг тэтгэх ажил төрийн бодлогын зиндаанд тавигдсан байна. Чингис хаан (1162-1227) улаан хулгана жилийн (1218 оны) цагаан сарын шинийн нэгний өдөр гаргасан нэгэн зарлигтаа “Миний эх (Өүлэн)-ийн нас сүүдэр далан долоог хүрч өндөр болсон учир их хүү (Чингис хаанаас)-гээс шар алт мянган лан, цагаан мөнгө түмэн лан, зодон арван түмэн хэсгийг гаргаж миний харьяат 892 хот, балгадын сан хөмрөгийг нээж, 60 наснаас дээшихэд 1 хувь, 70 наснаас дээшихэд 2 хувь, 80 наснаас дээшихэд 3 хувь, 90 наснаас дээшихэд 4 хувь, 100 наснаас дээшихэд 5 хувь, 110 наснаас дээшихийг налад бараалхуул өвөрмөц шагнана. 120 наснаас дээшихийг олдмогц урьд улсын “Кувв луу” цол өргөж, таяг тулуулан надад бараалхуул, өөр өргөмжлөл бий. Хэрэв үүнээс дээш давсан аваас сүйх тэргэнд суулгаж, дамнан ирүүлж бараалхуул, ангид ялгал бий. Энэхүү нэгэн хувьд нэг лан мөнгө, нэгэн бөс бараа, арван суулга амуу будааг хэмжээ болгон өг. 80 нас гарсан настанд шар алт нэг цэнг нэмж өг” гэжээ¹.

Чингисийн дараагаар хаан ширээг залгамжилсан Өгөдэй хаан (1187-1241) өнчин ядуусыг тэтгэх, тэднээс алба татвар авахгүй байхыг зарлиг болгож, ядууст тусламж үзүүлэх “сан” байгуулсан тухай “Монголын нууц товчоо”-ны 280-р зүйлд тусгагджээ.

“...Зуун хониноос нэжгээд (нэг) зусаг хонь гаргаж, үгээгүй ядуу хүмүүст тусламж болгож өгвөл сайн, ...зүг зүгийн мянгадаас хаан (Өгөдэй)-ы зарлигаар жил тутам, ...зуун хониноос нэжгээд зусаг хонь гаргуулав.” гэсэн нь ядуусыг тэтгэх сан байгуулсны нотолгоо юм. Чингис богд, Өгөдэй далай хааны дээрх зарлигууд нь өндөр насалсан өтгөс буурлууд, дайн дажин үймээн самууны улмаас аж амьдрал нь доройтсон өнчин ядуу иргэдээ төрөөс туслах, дэмжих төвлөрсөн хөрөнгийн нөөц бий болгох асуудлыг улс гүрний хэмжээгээр тухайн цаг үеийн онцлогтой нийцүүлэн өвөрмөцөөр шийдвэрлэсэн баримт болой. Эл бодлого нь Монголын дараа дараагийн хаадын бодлогод ч уламжлагдаж байсан байна.

1911 оны үндэсний хувьсгалын үр дүнд тогтсон шинэ Монгол улс, их, бага хаадын бодлогын залгамж чанарыг хадгалан, анх үүссэн цагаасаа нийгмийн хамгааллын асуудалд анхаарал тавьж эхэлжээ. Богд Жавзундамба 1912 оны 1-р сарын 1-нд буулгасан зарлигт “... Далан наснаас дээш наян насанд хүртэлх хөгшдөд мөнгө гурван лан, наян наснаас ерэн насанд хүртлэхэд зургаан лан, ерэн наснаас дээш зуун нас хүрэгсдэд есэн лан, нэгэн зуун насанд хүрснийг мэдүүлэн ирүүлээд жич өршөөн шагнахыг үзүүлтүгэй” гэжээ. Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл.² Богд хааны соёрхон баталсан зарлигаар тогтоосон “Монгол улсын хууль зүйн бичиг”-т өнчин хөгшнийг хураан тэтгэх нь, “Аливаа гамшигт орсон ардыг толилуулан шийтгэх нь” гэж бүлэглэн

¹ Инжинаш “Хөх судар”, 3-р дэвтэр (1153-1154 тал)

² Баримт бичгийн эмхтгэл (1900-1914). УБ.1982. 126 дахь тал

зааж зүйлчлэн хуульчилжээ. Богд Чингис хааны одоогоос 800 жилийн өмнө 60 наснаас эхлэн хүндэтгэл үзүүлж шагнаж урамшуулж байсан тэруламжлал өнөөгийн ахмад настанд тооцож 60 наснаас тэтгэвэр олгож, хангамж, хөнгөлөлт эдлүүлж буй нь манай төрийн бодлогын уламжлал, залгамж чанарын илэрхийлэл юм.

Монгол оронд нийгмийн эмзэг хэсэгт хамаарагдах өндөр настан, хөдөлмөрийн чадваргүй ядуу зүдүү иргэдийн нийгмийн хамгааллын хангалтыг эх үүсвэрийн талаас нь 3 хувааж болно.

Нэгдүгээрт: Төрийн бодлого, хууль, зарлигийн дагуу олгогдож байсан эд материалын хангамж;

Хоёрдугаарт: Аав, ээж, ураг төрлийн холбоотой ахан дүүсийн хүндлэх асрамжлах, халамжлах ёс горим, зан заншил, уламжлалын дагуу хангаж байсан эд материалын хангамж;

Гуравдугаарт: Нутаг нуга, хөрш зэргэлдээ айл, өрх, сайн санаат танил дотно хүмүүсээс дэмжлэг, туслалцаа үзүүлэх чиглэлээр хангаж байсан эд материалын хангамж.

Монгол улсын улс төр, эдийн засаг, нийгмийн байгуулал тухайн цаг үеийн гадаад, дотоод нөхцөл байдалд нийцэж бас өвөрмөц зам туулж иржээ. Тийм болохоор 1921 оны ардын хувьсгалаас хойш 80 гаруй жилийг Монгол дахь нийгмийн хамгаалал жинхэнэ ёсоор бүрэлдэн тогтсон хөгжил, шинэчлэлийн түүхэн үе гэхэд болно. Энэ үе маань бас цаг цагийн онцлогоос үүдэлтэй өвөрмөц шинжийг хадгалж иржээ. Монголын төр засаг өндөр настан, хөдөлмөрийн чадваргүй, амьдрал ахуй нь хүнд, гачигдал зовлонтой иргэдийг асран хамгаалах, тэтгэн туслах явдлыг төрөөс зохицуулж байсан XIII-XX зууны эхэн үеийн уламжлалыг 1921 оноос хойш эдүгээ хүртэлх хугацаанд агуулга, хэлбэрийн хувьд улам хөгжүүлэн баяжуулж ирэв.

Ийнхүү нийгмийн эмзэг хэсэг төдийгүй,

нийт иргэдийн нийгмийн хамгааллыг бүхэлд нь хамгаалах нийгмийн даатгал, нийгмийн халамжийн бие даасан тогтолцоо болон өргөжиж нийгмийн хамгааллын алба үүсч, эрх зүйн орчин бүрдэж, бүтэц, зохион байгуулалт нь боловсронгуй болж, хөрөнгө, санхүүгийн төвлөрсөн, найдвартай эх үүсвэрээр хангагдаж шинэчлэгдсээр ирсэн нь уламжлал, шинэчлэлийн шүтэлцээний түүхэн онцлог юм.

2. Нийгмийн хамгааллын хөгжлийн үе шатууд, онцлог

Монгол улсын нийгмийн хамгааллын тогтолцооны хөгжлийг дараах үе шатанд хувааж болно.

- Нийгэм хангамжийн зарим төрөл, хэлбэр бий болж, хөгжлийн хөрс суурь тавигдсан үе (1921-1940);
- Нийгмийн даатгалын алба бүрэлдэж бэхжсэн үе (1941-1960);
- Социалист үйлдвэрлэлийн харилцааг хөгжүүлэх, социализмын материал техникийн бааз байгуулах үеийн нийгмийн даатгал, нийгэм хангамжийн тогтолцоо (1961-1990);
- Нийгэм хангамжийн тогтолцоог шинэчлэх, өөрчлөх, эрх зүйн орчин бүрдсэн үе (1991-1994);
- Монгол Улс нийгмийн даатгалын шинэ тогтолцоонд шилжсэн үе (1995-2006).

Ардын хувьсгалын ардчилсан шат (1921-1940)-нд иргэдийн материаллаг хангамжийг сайжруулах талаар авсан арга хэмжээний үр дүнд иргэдэд зарим төрлийн тэтгэвэр, тэтгэмж олгох, өндөр настан, хөдөлмөрийн чадваргүй иргэдийг асран тэтгэх, нийгмийн үйлчилгээ зэрэг нийгэм хангамжийн зарим үндсэн хэлбэрүүд бий болов. Ардын засгийн газар 1923 оноос эхлэн байлдаанд явж байгаад шархадсан, нас барсан хүмүүсийн ар гэрт болон ядуус, жинхэнэ цэргийн гэр бүлд улсын сангаас тэтгэвэр, тусламж

олгох дүрэм, тогтоол гаргаж байжээ. 1925 оны Аливаа хүчин үнэлэгчдийн дүрэм, 1930 оны хөдөлмөрийн хуульд ард түмэнд сайн дурын үндсэн дээр чөлөөтэй хөдөлмөрлөх эрх олгож, хөдөлмөрийн хүн хөдөлмөрийн чадвараа алдахад эд материалын тусламж, тэтгэвэр олгохоор хуульчилжээ. Монгол улсын иргэдийн өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдахад материалын хангамж эдлэх эрхийг 1940 онд батлагдсан Үндсэн Хуулиар анх удаа тунхагласан. Үндсэн Хуулийн 91 дүгээр зүйлд “Монгол улсын хөлсний ажил хийгч ард иргэн нь нас хөгшрөх цагт, мөн түүнчлэн өвдөх, хөдөлмөрийн чадвар алдвал эдийн тусламж авах эрхтэй” гэжээ. 1930-1940 онд улсын төсвийн орлого 27.4-өөс 111.4 сая төгрөгт хүрч 4 дахин, нийгэм хангамжийн зардал 0.085-аас 0.45 сая төгрөг болж 5.3 дахин нэмэгджээ.

Социализмын үндсийг байгуулах шатанд шилжих үе (1941-1960)-ийн гол ололт нь хөдөө аж ахуй, аж үйлдвэр амжилттай хөгжиж, хөдөө аж ахуйд хоршоолох хөдөлгөөн ялснаар улс ардын аж ахуйн бүх салбарт социалист үйлдвэрлэлийн харилцаа ялсан гэж үзэж байв. Энэ үеийн гол онцлог нь улс орны үйлдвэрлэх хүчний хөгжилт, ажиллагсдын тооны өсөлт, нийгэм эдийн засгийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн нийгмийн даатгалын эрх зүйн орчинг бүрдүүлж, өөрийгөө санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэртэй болж, нийгмийн даатгалын алба байгуулагдан бэхжиж, тэтгэвэр, тэтгэмжийн хангамж сайжирч, нийгмийн даатгалын болон нийгэм хангамжийн үйлчилгээний хүрээ өргөжиж хөгжсөн үе байлаа.

1941 онд батлагдсан Хөдөлмөрийн хуулиар “Нийгмийг аюулаас хамгаалах явдал” гэсэн 16 дугаар бүлгийг бие даалган оруулж, ажилчин, албан хаагчдын нийгмийн даатгалыг нарийвчлан зааж, нийтээр нь даатгалд хамруулж, хангах эх үүсвэр, хэмжээ, төрлийг тогтоосон.

Монгол улсын Ардын сайд нарын Зөвлөлийн 1942 оны 2 дугаар тогтоолоор “Монгол улсын дотор дагаж шийтгүүлэх

нийгмийг аюулаас хамгаалах дүрэм”-ийг баталжээ. Эл тогтоолоор 1942 оны 2 дугаар сарын 1-нээс эхлэн нийгмийг аюулаас хамгаалах хөрөнгийг зарцуулах эрхийг МҮЭ-ийн төв зөвлөлд олгож, нийгмийн даатгалын ажлыг эрхлэх, нийгмийг аюулаас хамгаалах хэлтсийг МҮЭ-ийн төв зөвлөлд байгуулахаар шийдвэрлэсэн. Энэ үндсэн дээр МҮЭ-ийн Төв Зөвлөлийн Тэргүүлэгчдийн 1942 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 27 дугаар хуралдааны тогтоолоор МҮЭ-ийн төв зөвлөлийн аппаратад Нийгмийг аюулаас хамгаалах хэлтсийг дарга 1, сургагч бөгөөд доктор 1, байцаагч 2, бүгд 4 орон тоотойгоор байгуулж ажиллуулсан. Эрх зүйн орчны бүрдэлт, хөрөнгийн эх үүсвэрийн хангалт, нийгмийн даатгалын ажлыг эрхлэх багууллага (нийгмийн аюулаас хамгаалах хэлтэс байгуулагдсан) бий болсон зэргийг харгалзан 1942 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийг нийгмийн даатгалын алба анх үүссэн өдрөөр тогтоон, энэ өдрийг орон даяар тэмдэглэх болсон бөгөөд энэ онд 65 жилийн ой нь тохиож байна.

Нийгмийн даатгалын орлого, зарлагыг 1943 оноос эхлэн улсын төсөвт бие даасан үзүүлэлт болгож, тусгах болжээ. Монгол улсын тэтгэврийн анхны хууль 1958 онд батлагдсан. Тэтгэврийн хууль тэтгэврийн төдийгүй, Монгол улсын нийгэм хангамжийн эрх зүйн хөгжлийн түүхэнд гарсан чухал үйл явдлын нэг байв. 1960 онд батлагдсан шинэ үндсэн хуулийн 79 дүгээр зүйлд “Монгол улсын иргэд нас хөгшрөх, мөн өвдөх, хөдөлмөрийн чадвар алдах, тэжээгчээ алдахад эдийн тусламж авах эрхтэй” гэж заажээ.

Монгол улсад нийгэм хангамж нь дараах 4 хэлбэрээр хэрэгжсэн. Үүнд:

1. Ажилчин, албан хаагчдын нийгмийн даатгал
2. Хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүдийн нийгмийн даатгал
3. Улсын төсвөөс санхүүжүүлж буй нийгэм хангамж
4. Эмнэлгийн үнэ төлбөргүй тусламж

1945-1960 онд нийгмийн даатгалын орлого 4.5 саяас 51.5 сая төгрөг болж, 11.4 дахин, зарлага 3.9 саяас 43.7 сая төгрөг хүрч, 11.2 дахин өсчээ.

Социалист үйлдвэрлэлийн харилцааг хөгжүүлж, социализмын материал техникийн бааз өрнүүн байгуулах шатанд шилжих үе (1961-1990)-д улс ардын аж ахуйн салбарууд бэхжиж, эдийн засгийн хөгжлийн түвшин өндөр хурдацтай байлаа. Мөн банк, санхүүгийн тогтолцоо хэлбэрээ олж, соёл, боловсрол, шинжлэх ухаан, эрүүлийг хамгаалах салбарууд амжилттай хөгжжээ. Үүний нотолгоо нь 1990 онд нийгмийн нийт бүтээгдэхүүн 1970 оныхоос 4.4 дахин, үндэсний орлого 2.7 дахин, улс ардын аж ахуйн нийт салбарын үндсэн фонд 1960 оныхоос 10.5 дахин, ажиллагсдын тоо 1.8 дахин тус тус өссөнөөр илэрхийлэгдэж байна.

Сайд нарын Зөвлөл 1970 оны 217 дугаар тогтоолоор МҮЭ-ийн Төв Зөвлөл, Батлан хамгаалах яамны эрхэлж байсан тэтгэврийн асуудлыг Сангийн яаманд төвлөрүүлж, нийгэм хангалтын хэлтсийг 5 хүний орон тоотойгоор байгуулсан.

Сайд нарын зөвлөл 1974 оны 124 дүгээр тогтоолоор нийгэм хангамжийн ажлыг улсын хэмжээгээр зохион байгуулж удирдах үүрэг бүхий улсын нийгэм хангамжийн газрыг Хөдөлмөр цалин хөлсний улсын хорооны харьяанд байгуулсан. Сангийн яамны нийгэм хангалтын хэлтэс, тус газарт нийлсэн юм. Ийнхүү нийгэм хангамжийн ажлыг төрийн захиргааны байгууллагад төвлөрүүлснээр улсын нийгэм хангамжийн бие даасан тогтолцоо зохион байгуулалтын хувьд бүрэлдэн тогтов. МҮЭ-ийн Төв Зөвлөл нь нийгмийн даатгал, амралт, сувиллын асуудлыг 1942-1990 онд нийтдээ 48 жил эрхлэн хариуцаж ажиллажээ. МҮЭ-ийн Төв Зөвлөлд 1962 оноос нийгмийн даатгал, рашаан амралтын газар, 1976 оноос нийгмийн даатгал, амралт, рашаан сувиллын хэргийг эрхлэх ерөнхий газар нэртэйгээр ажиллаж байв.

Монгол Улсын Засгийн газар 1990 оны 220 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн

яамны Нийгэм хангамжийн газар, МҮЭТЗ-ийн амралт, рашаан сувилалын газрыг татан буулгаж, Хөдөлмөрийн яамны харьяанд Улсын нийгэм хангамжийн газар байгуулсан. Тус газрын үндсэн үүрэг нь улсын нийгэм хангамж, нийгмийн даатгалын нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, нийгмийн даатгалын хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, хяналт тавих, иргэдэд тэтгэвэр, тэтгэмж тогтоож олгох, асрамж, амралт, сувиллын үйлчилгээг сайжруулах ажлыг удирдан зохион байгуулах явдал байв. Ийнхүү нийгмийн хамгааллын үйлчилгээ нь нийгэм хангамж, нийгмийн даатгал гэсэн хоёр чиглэлээр хөгжиж ирснийг төвлөрүүлж нэгтгэснээр нийгэм хангамжийн бие даасан тогтолцоо бүрэн утгаараа бий болов.

Нийгмийн хамгааллын салбарын гол онцлог нь нийгэм хангамж, нийгмийн даатгалын эрх зүйг боловсронгуй болгох, хамрах хүрээг өргөтгөх, тэтгэвэр тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх, хөнгөлөлт, нэмэгдэл, үйлчилгээний шинэ төрлийг бий болгох, нийгмийн даатгал, нийгэм хангамжийн олон талт үйлчилгээг сайжруулах, эдгээр албадыг материаллаг бааз, боловсон хүчнээр бэхжүүлэх замаар дорвитой арга хэмжээнүүд авагдсан үе байв. 1961-1990 онд нийгэм хангамжийн арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө 53.4 дахин, нийгэм хангамжийн зарлагын улсын төсвийн зарлагад эзлэх хувь 7.3 пунктээр өслөө.

3. Нийгэм хангамжийн тогтолцоог шинэчлэх, нийгмийн даатгалын тогтолцоонд шилжих эрх зүйн орчинг бүрдүүлэх нөхцлийг хангасан нь (1991-1994)

Монгол орон 1990 оноос ардчилсан нийгэмд шилжиж орсон. Нэг талаас ЗХУ-ын зүгээс үзүүлдэг зээл тусламж зогсож, нөгөө талаас Монголын үйлдвэрийн бүтээгдэхүүнийг борлуулах зах зээл хаагдлаа. Үүнээс болж манай оронд байсан 6000 орчим үйлдвэр, үйлчилгээний газар дампуурч, төрийн санхүүжилтээр

явагддаг нийгэм, соёлын үйл ажиллагаа зогсоход хүрсэн.

1991 онд 1989 оны гүйцэтгэлээс дотоодын нийт бүтээгдэхүүн 11.5, үндэсний нийт бүтээгдэхүүн 5.5, экспорт 51.8, импорт 62.5, улсын төсвийн орлого 5.9 хувиар тус бүр буурч, улсын төсвийн зарлага 26.4 хувиар нэмэгдэв.

Улс төрийн тогтвортой байдал, нийгмээ дэлхий дахины хүн ардын олон жилийн түүхэн туршилгаар шалгагдсан жам ёсны хөгжлийн нийтлэг зарчим, жишигээр үйл ажиллагаа, амьдрал ахуйгаа зохицуулдаг байх нь амьдралын шаардлага боллоо.

Тэтгэмжийн тухай, Улсын нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хуулиуд 1991 онд батлагдсан. Тэтгэврийн шинэчлэлийн хуулиар тэтгэврийг тэтгэврийн сангаас олгох болж, тэтгэврийн сангийн дүрэм баталсан. Ажилтнуудаа зах зээлийн харилцаан дахь нийгмийн даатгал, нийгэм хангамжийн тогтолцоо, эрх зүй, үйл ажиллагаатай танилцуулах, энэ талын мэдлэг, дадлагатай болгох шаардлага тавигдаж, энэ үүднээс Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ)-тай харилцаа холбоо тогтоож, хамтран ажиллаж эхэлсэн.

ОУХБ, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн туслалцаа, дэмжлэгтэйгээр нийгэм хангамжийн ажилтнууд, ажил олгогч, даатгуулагч, ТББ-ын төлөөлөл оролцсон сургалт, семинарыг олон удаа зохион явуулсан. Энэ үеийн хамгийн том гавьяа бол нийгмийн даатгалын багц хуулиудыг боловсруулан 1994 онд батлуулсан явдал юм. 1991-1994 онд нийгэм хангамжийн нийт орлого 17.1, шимтгэлийн орлого 25.5, төсвөөс олгосон санхүүжилт 13.4, зарлага 16.5 дахин тус тус өссөн байна.

4. Монгол улс нийгмийн даатгалын шинэ тогтолцоонд шилжсэн үе (1995 - 2006)

Нийгмийн даатгал бол хөгжлийн чухал ололт юм. Нийгмийн даатгал нь төрийн нийгмийн бодлогыг хэрэгжүүлэх механизм, хүн амын нийгмийн хамгааллыг

зохион байгуулах үндэс болно.

Нийгмийн даатгал Германд 1883 онд үүссэн. Германы нийгмийн даатгалын тогтолцоог Австри, Англи, Орос, Япон зэрэг улс орнуудад авч хэрэгжүүлсэн ба АНУ, Канад болон Латин Америкийн орнуудад түгсэн. Өнөөдөр нийгмийн даатгалын аргыг дэлхий даяар бараг бүх оронд хэрэглэж байна.

Монгол улс зах зээлийн харилцаанд шилжих стратегийн зорилтыг хэрэгжүүлэх явцад нийгмийн хүрээнд хийсэн томоохон шинэчлэлийн нэг нь нийгмийн даатгалын тогтолцоог зах зээлийн харилцаанд нийцүүлэн шинээр бүрдүүлсэн явдал юм.

Өмчийн олон хэвшил бий болж, иргэдийн нийгмийн хамгааллын төлөө төр төдийгүй, аж ахуйн нэгж, байгууллага, эзэд, даатгуулагч, иргэд өөрсдөө хариуцлага хүлээх болсон нөхцөлд хуучин төлөвлөгөөт эдийн засгийн үеийн нийгэм хангамжийн тогтолцоог хөрөнгийн эх үүсвэрийн бүрдэлт, эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалтын хэлбэр, арга механизмын хувьд үндсээр нь өөрчлөх шаардлагатай боллоо. Үүнийг үндэслэн нийгмийн даатгалын хуулиудыг баталж 1995 оноос эхлэн мөрдсөн нь чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон юм.

Нийгмийн даатгал гэдэг нь иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжинд байсан хүмүүст хууль тогтоомжинд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Шинэ тогтолцооны онцлог нь:

- Иргэн өөрөө хохирч болзошгүй тохиолдол болоход урьдчилан даатгагдсан байна.
- Даатгуулагч зохих болзол, нөхцлийг хангасан тохиолдолд нийгмийн

даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх эдэлнэ.

- Ажил олгогч, даатгуулагч хоёр нийгмийн даатгалын санг бүрдүүлэхэд тэгш эрхтэй оролцож, хариуцлага хүлээнэ. Нийгмийн даатгалын сангийн орлогын 47.2 хувийг ажил олгогч, 24.3 хувийг даатгуулагч, 25.1 хувийг төр бүрдүүлж байна.
- Үйлдвэрлэлийн ослын даатгалыг шинээр бий болгож шимтгэлийг нь ажил олгогч хариуцна.
- Ажилгүйдлын даатгалыг шинээр бий болгов.
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний болон ажилгүйдлийн даатгалын хоёр төрлийг шинээр бий болгосноор ОУХБ-ын 1952 оны 102-р конвенцийн заалтууд Монгол оронд бүрэн хэрэгжив.
- Нийгмийн даатгал, нийгмийн

олгогчийн үүрэг гүйцэтгэх ба урьд тэтгэвэр тогтоогдсон иргэдийн хувьд санхүүгийн дэмжлэг үзүүлэгч болов.

- Нийгмийн даатгалд хамрагдаагүй, нийгмийн даатгалын хуулинд заасан тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсээгүй иргэд болон эхчүүд, хүүхэд, ахмад настан, тахир дутуу хүмүүст нийгмийн халамжийн хуулийн дагуу нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж олгож, хөнгөлөлт эдлүүлж, үйлчилгээ үзүүлэх болов.

Төрөхөөс эхлээд нас барах хүртлээ, мөн зарим тохиолдолд нас нөгчсөний дараа ч гэр бүлийн гишүүд нь нийгмийн даатгалаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авч хангамж эдэлдэг. Энэ утгаар нь авч үзвэл нийгмийн даатгал иргэдийн амьдралын баталгаа болдог. Нийгмийн даатгалын хөгжлийг дараах зарим үзүүлэлтээс харж болно.

№	Үзүүлэлт	1995 он	2005 он	2005/1995 Өсөлт (хувиар)
1	Даатгалд хамрагдсан ажил олгогчийн тоо	14,069	16,685	18,6
2	Даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо /мян/	2006,1	1988,4	0,9
3	НД-ын сангийн орлого /сая төгрөг/	30664,1	176349,8	5,7 дахин
4	НД-ын сангийн зарлага (сая төгрөг)	24888,3	155854,2	6,3 дахин
5	Тэтгэвэр авагчдын тоо	284277	283651	0,2
6	Тэтгэвэрт олгосон хөрөнгө /сая төгрөг/	17584,9	125413,6	7,1 дахин
7	Сарын дундаж тэтгэвэр	5200	36800	7,1 дахин
8	НД-ын сангийн орлогын ҮНО-д эзлэх хувь	5,7	7,2	1,5
9	НД-ын сангийн зарлагын ҮНО-д эзлэх хувь	4,7	6,6	1,9

халамжийн хоёр арга, хэлбэр холилдон хавсарч байсан нийгэм хангамжийн тогтолцоог хөрөнгийн эх үүсвэрийн бүрдэлт, зарцуулалтын байдлаар ялгаж, “Нийгмийн даатгал”, “Нийгмийн халамж” гэсэн хоёр дэд бүтцээр зааглан эрх зүйн зохицуулалтаар баталгаажуулсан.

- Төрийн үүрэг оролцоо өөрчлөгдөж, нийгэм хангамжийн зардлыг бараг дангаараа хариуцаж байсан төр зөвхөн төрийн албан хаагчийн хувьд ажил

Монгол улсын нийгмийн даатгалын тогтолцоо нь олон улсын нийтлэг жишигт нийцсэн, нийгмийн даатгалын үндсэн зарчмыг хангасан тогтолцоо болж чалсаныг ОУХБ-ын шинжээчид судалж тогтоосон үнэлгээ байдаг.

Ашигласан материал

Инжинаш “Хөх судар”, 3-р дэвтэр (1153-1554 тал)